

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/04/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зуунмод 2022 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273204 Цахим хаяг: maitsetsegt@audit.gov.mn



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа.....	17
4.2 Төлбөрийн акт	18
4.3 Албан шаардлага	18
4.4 Зөвлөмж	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
НХМ	Нэг хэвийн маягт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70272248, Факс: 70272582, Имэйл: tuv@audit.gov.mn

2022.02.22 № 01/39
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА Н.ЭНХБАТ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ
19020205

D 2022/2022 он/ALBAN BICHIG

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгд	Эцсийн үлдэгд
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	45,753,951.68	69,345,354.56
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	141,500.00	2,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	141,500.00	2,000.00
3121	Төгрөг	141,500.00	2,000.00
31213	Арилжааны банк дахь харилцах	141,500.00	2,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	45,612,451.68	69,343,354.56
351	Түүхий эд материал	19,264,248.81	18,235,417.56
35110	Тусгай зориулалттай материал	19,264,248.81	18,235,417.56
35300	Бэлэн бүтээгдэхүүн	2,295,580.00	2,381,560.00
354	Хангамжийн материал	24,052,622.87	48,726,377.00
35410	Бичиг хэргийн материал	4,689,576.87	6,881,310.00
35420	Аж ахуйн материал	8,107,826.00	15,101,327.00
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	1,086,000.00
35470	Бусад хангамжийн материал	11,255,220.00	25,657,740.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	729,309,168.20	955,231,914.83
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	729,309,168.20	955,231,914.83
392	Биет хөрөнгө	716,859,168.20	942,781,914.83
39201	Барилга, байгууламж, орон сууц	688,700,983.00	688,700,983.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-11,478,349.68	-22,956,699.36
39203	Авто-тээврийн хэрэгсэл	58,000,000.00	75,140,563.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-49,783,332.99	-57,011,713.19
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	260,420,585.97	332,217,760.41
39206	Хуримтлагдсан элэгдэл	-245,589,944.68	-103,364,205.16
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	58,170,963.92	76,713,905.92
39208	Хуримтлагдсан элэгдэл	-42,556,604.29	-47,299,306.78
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,342,400.00	3,342,400.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,367,533.05	-2,701,773.01
393	Биет бус хөрөнгө	12,450,000.00	12,450,000.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-550,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	12,450,000.00	12,450,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	775,063,119.88	1,024,577,269.39
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	141,500.00	2,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	141,500.00	2,000.00
414	Урьдчилж орсон орлого	141,500.00	2,000.00
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	141,500.00	2,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	774,921,619.88	1,024,575,269.39
51	Засгийн газрын хувь оролцоо	774,921,619.88	1,024,575,269.39
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	190,213,991.97	190,213,991.97
51101	Өмч: - төрийн	177,763,991.97	177,763,991.97
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	12,450,000.00	12,450,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	584,707,627.91	834,361,277.42
51210	Өмнөх үеийн үр дүн	584,707,627.91	584,707,627.91
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	249,653,649.51
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	775,063,119.88	1,024,577,269.39

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	862,383,408.90	1,083,706,461.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	36,377,108.90	333,343,161.00
120	Нийтлэг татварын бус орлого	36,377,108.90	333,343,161.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	36,377,108.90	333,343,161.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	36,377,108.90	333,343,161.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	826,006,300.00	750,363,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	663,572,700.00	666,322,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	663,572,700.00	666,322,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	162,433,600.00	84,041,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	162,433,600.00	84,041,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	880,282,648.29	833,799,811.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	880,282,648.29	833,799,811.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	872,321,841.95	828,494,040.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	533,962,850.50	539,354,479.68
210101	Үндсэн цалин	437,756,186.61	426,473,675.92
210102	Нэмэгдэл	84,531,863.89	101,029,403.76
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,674,800.00	11,851,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,715,542.16	70,436,668.52
210201	Тэтгэврийн даатгал	45,950,812.95	49,471,229.53
210202	Тэтгэмжийн даатгал	5,276,873.13	5,493,172.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,207,578.65	4,371,017.84
210204	Ажилгүйдлийн даатгал	1,025,188.93	1,009,204.92
210205	Эрүүл мэндийн даатгал	10,255,088.50	10,092,044.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,029,535.00	35,459,686.82
210301	Гэрэл, цахилгаан	1,902,329.00	1,871,230.82
210302	Түлш, халаалт	29,002,512.00	29,002,567.00
210303	Цэвэр, бохир ус	2,124,694.00	4,585,889.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,957,953.20	40,939,570.22
210401	Бичиг хэрэг	10,741,479.30	7,019,066.87
210402	Тээвэр, шатахуун	2,334,333.00	688,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,916,829.00	3,089,142.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,367,011.90	26,332,129.00
210408	Бараа материал акталсны зардал	4,358,300.00	3,631,232.35
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	626,800.00	1,786,150.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	902,550.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	626,800.00	500,000.00
210604	Урсгал засвар	00.00	383,600.00
2107	Томилолт, зочны зардал	36,000.00	115,500.00
210702	Дотоод албан томилолт	36,000.00	115,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,278,967.90	18,108,240.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	484,860.00	548,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	360,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	74,250.00	120,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	103,660.00	62,446.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	00.00
210807	Газрын төлбөр	6,000.00	37,350.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	21,288,197.90	16,979,544.90

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	191,714,193.19	122,293,744.17
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	160,715,479.00	83,692,295.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,586,000.00	810,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,412,714.19	37,791,448.37
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,960,806.34	5,305,771.18
2132	Бусад урсгал шилжүүлэг	528,900.00	432,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	528,900.00	432,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,431,906.34	4,873,771.18
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	4,524,966.98
213304	Хөрөнгийн	7,431,906.34	348,804.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-17,899,239.39	249,906,649.51
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	253,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	253,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-253,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-17,899,239.39	249,653,649.51

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	177,763,991.97	00.00	-51,748,831.37	00.00	126,015,160.60
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	177,763,991.97	00.00	-51,748,831.37	00.00	126,015,160.60
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	12,450,000.00	00.00	366,421,460.49	00.00	378,871,460.49
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190,213,991.97	00.00	584,707,627.91	00.00	774,921,619.88
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190,213,991.97	00.00	584,707,627.91	00.00	774,921,619.88
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	190,213,991.97	00.00	584,707,627.91	00.00	774,921,619.88
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	249,653,649.51	00.00	249,653,649.51
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190,213,991.97	00.00	834,361,277.42	00.00	1,024,575,269.39

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,089,342,347.30	991,591,148.94
11	ТАТВАРЫН ОРЛОГО	27,248,706.23	15,919,514.84
118	Бусад татвар, төлбөр, хураамж	27,248,706.23	15,919,514.84
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	27,248,706.23	15,919,514.84
118001	Улсын тэмдэгтийн хураамж	27,248,706.23	15,919,514.84
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	236,087,341.07	225,308,334.10
120	Нийтлэг татварын бус орлого	236,087,341.07	225,308,334.10
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	236,087,341.07	225,308,334.10
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	236,087,341.07	225,308,334.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	826,006,300.00	750,363,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	663,572,700.00	666,322,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	663,572,700.00	666,322,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	162,433,600.00	84,041,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	162,433,600.00	84,041,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,088,488,347.30	991,730,648.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,088,488,347.30	991,730,648.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	817,332,993.66	745,057,528.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	533,962,850.50	539,354,479.68
210101	Үндсэн цалин	437,756,186.61	430,075,439.51
210102	Нэмэгдэл	84,531,863.89	97,521,140.17
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,674,800.00	11,757,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,715,542.16	70,436,668.52
210201	Тэтгэврийн даатгал	45,950,812.95	49,973,900.39
210202	Тэтгэмжийн даатгал	5,276,873.13	5,198,838.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,207,578.65	4,158,790.99
210204	Ажилгүйдлийн даатгал	1,025,188.93	1,009,812.84
210205	Эрүүл мэндийн даатгал	10,255,088.50	10,095,325.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,029,535.00	35,459,686.82
210301	Гэрэл, цахилгаан	1,902,329.00	1,871,230.82
210302	Түлш, халаалт	29,002,512.00	29,002,567.00
210303	Цэвэр, бохир ус	2,124,694.00	4,585,889.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,342,009.00	12,172,652.00
210401	Бичиг хэрэг	8,338,880.00	6,119,400.00
210402	Тээвэр, шатахуун	2,334,000.00	688,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,916,829.00	3,089,142.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,512,300.00	2,096,110.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	954,800.00	1,887,550.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	88,000.00	1,012,550.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	866,800.00	500,000.00
210604	Урсгал засвар	00.00	375,000.00
2107	Томилолт, зочны зардал	36,000.00	115,500.00
210702	Дотоод албан томилолт	36,000.00	115,500.00

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	990,778.00	1,128,696.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	484,868.00	548,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	360,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	74,250.00	120,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	103,660.00	62,446.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	00.00
210807	Газрын төлбөр	6,000.00	37,350.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	162,301,479.00	84,502,295.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	160,715,479.00	83,692,295.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,586,000.00	810,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	271,155,353.64	246,673,120.12
2132	Бусад урсгал шилжүүлэг	528,900.00	432,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	528,900.00	432,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	263,194,547.30	245,892,315.92
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	27,193,706.23	15,974,514.84
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	4,524,966.98
213304	Хөрөнгийн	236,000,841.07	225,392,834.10
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	7,431,906.34	348,804.20
213404	Хөрөнгийн	7,431,906.34	348,804.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	854,000.00	-139,500.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	712,500.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	712,500.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	712,500.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	712,500.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-712,500.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	141,500.00	-139,500.00
9	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	141,500.00
10	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	141,500.00	2,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	666,322,200.00	661,797,233.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	666,322,200.00	661,797,233.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	665,890,200.00	661,365,233.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	539,354,500.00	539,354,479.68
210101	Үндсэн цалин	456,196,500.00	430,075,439.51
210102	Нэмэгдэл	71,278,000.00	97,521,140.17
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,880,000.00	11,757,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,062,800.00	70,436,668.52
210201	Тэтгэврийн даатгал	52,488,700.00	49,973,900.39
210202	Тэтгэмжийн даатгал	4,893,500.00	5,198,838.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,914,800.00	4,158,790.99
210204	Ажилгүйдлийн даатгал	978,700.00	1,009,812.84
210205	Эрүүл мэндийн даатгал	9,787,100.00	10,095,325.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,935,600.00	35,459,686.82
210301	Гэрэл, цахилгаан	3,537,600.00	1,871,230.82
210302	Түлш, халаалт	28,031,400.00	29,002,567.00
210303	Цэвэр, бохир ус	5,366,600.00	4,585,889.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,217,300.00	12,172,652.00
210401	Бичиг хэрэг	6,120,000.00	6,119,400.00
210402	Тээвэр, шатахуун	688,500.00	688,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,952,000.00	3,089,142.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариут	353,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,103,800.00	2,096,110.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,925,000.00	1,887,550.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,050,000.00	1,012,550.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	375,000.00	375,000.00
2107	Томилолт, зочны зардал	312,000.00	115,500.00
210702	Дотоод албан томилолт	312,000.00	115,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хур	1,273,000.00	1,128,696.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	585,000.00	548,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	366,000.00	360,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	120,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,000.00	62,446.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	01.00
210807	Газрын төлбөр	60,000.00	37,350.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	810,000.00	810,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	810,000.00	810,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	432,000.00	432,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	432,000.00	432,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	432,000.00	432,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	666,322,200.00	666,322,200.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	666,322,200.00	666,322,200.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	666,322,200.00	666,322,200.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	141,500.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	2,000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	48.00	48.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	40.00	40.00
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00
620004	Гэрээт ажилтан	02.00	02.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	160,715,479.00	83,692,295.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	160,715,479.00	83,692,295.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	160,715,479.00	83,692,295.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	160,715,479.00	83,692,295.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	160,715,479.00	83,692,295.80
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	162,433,600.00	84,041,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	162,433,600.00	84,041,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	162,433,600.00	84,041,100.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн тооллого, тооцоо бодолттой холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Майцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 190 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь төр иргэнийг холбосон бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, төрийн бүртгэлийн үйлчилгээгээр иргэний эрхийг хангах явдлыг эрхэм зорилгоо болгон бүртгэлийн бодлогын нэгдмэл чанарыг хангах, үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх, улс орны эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлэх, бүртгэлийн үйл ажиллагааг төгөлдөршүүлэх, төрийн үйлчилгээг хүртээмжтэй шуурхай болгоход чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг, Хууль зүйн яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Иргэний бүртгэлийн үйл ажиллагаа
- Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа
- Хуулийн этгээдийн бүртгэлийн үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Улсын бүртгэлийн хэлтсийн 2019 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн А/02 тушаалаар "Дотоод хяналтын хороо" байгуулан ажиллах журмыг баталсан. Мөн 2016 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн даргын А/15 тушаалаар Өмч хамгаалах байнгын зөвлөл байгуулан ажиллах журмыг хавсралтаар баталсан байна.

Улсын бүртгэлийн хэлтсийн Дотоод хяналтын хороо нь 2021 оны жилийн ажлын төлөвлөгөөнд санхүү төсөв, эд хөрөнгийн ашиглалтын талаар 6 хэрэгжүүлэх арга хэмжээг тусган батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас бүтэн жилээр гаргаж ажилласан байна.

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний нийт зарлагаас 1,5 хувиар буюу 16,327.3 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 13,061.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний нийт зардлаас тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний нийт зарлагаас 1,5 хувиар буюу 14,875.9 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 11,900.7 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 1,451.4 мянган төгрөгөөр буурсан байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Улсын бүртгэлийн тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн алба нь “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд улсын төсвөөс 666,332.2 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан. Үндсэн үйл ажиллагааны орлого 200,000.0 мянган төгрөгийн төлөвлөгөөтэй, гүйцэтгэлээр 241,227.8 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, 120,6 хувийн биелэлттэй байна. Нэмэлт санхүүжилтийн дансанд 84,041.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 991,730.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд ОТМИМА ХХК-аас 17,140.6 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 18,834.7 мянган төгрөгийн тавилга эд хогшил, УБЕГ-аас Койка Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын төсөл буюу гадаадын хандив тусламжаар 227,198.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг бүртгэж, тайлагнасан. УБЕГ-аас 1,800.0 мянган төгрөгийн элэгдлээ нөхсөн зөөврийн компьютер ирснийг бүртгэж, 540.0 мянган төгрөгөөр дахин үнэлж бүртгэсэн байна. ТӨБЗГ-ын 2021 оны 7 дугаар сарын 08-ний өдрийн 329 тоот тогтоол, 2021 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн 720 тоот тогтоолын дагуу нийт 156,233.5 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

Бараа материалын дансанд УБЕГ-аас үнэ төлбөргүй шилжүүлсэн 69,578.9 мянган төгрөгийн, хандиваар 50.0 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 20,342.7 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 62,356.5 мянган төгрөгийн бараа материалыг хассан байна.

Авлага, өглөгийн талаар:

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар авлагын үлдэгдэл байхгүй, 2.0 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан. Энэ нь үйл ажиллагааны орлогын төвлөрүүлээгүй үлдэгдэл байна. Харилцагч бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулсан.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 00 төгрөгийн, арилжааны банкны харилцах дансанд 2.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Бараа материал 69,343.4 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 955,231.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөг/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	141.5	2.0	-139.5
Авлага	0	0	
Урьдчилгаа	0	0	
Бараа материал	45,612.4	69,343.4	23,730.9
Үндсэн хөрөнгө	729,309.2	955,231.9	225,922.7
Нийт хөрөнгө	775,063.1	1,024,577.3	249,514.2
Өр төлбөр	141.5	2.0	-139.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	774,921.6	1,024,575.3	249,653.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	775,063.1	1,024,577.3	249,514.2

Бараа материалын дансны үлдэгдэл 69,343.4 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 23,730.9 мянган төгрөгөөр өссөн нь УБЕГ-аас 69,578.9 мянган төгрөгийн үнэ төлбөргүй шилжүүлж, бараа материалын үлдэгдэл өссөнөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 955,231.9 мянган төгрөг болж 225,922.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 265,514.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,024,575.3 мянган төгрөг болж 249,653.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 836,175.3 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд 737,712.8 мянган төгрөг, татаас ба урсгал шилжүүлгийн зардалд 57,092.6 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 41,370.0 мянган төгрөг санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 169,853.1 мянган төгрөгөөр бууруулан 666,322.2 мянган төгрөгийн урсгал зардлыг санхүүжүүлэхээр баталсан байна. Энэ нь татаас ба урсгал шилжүүлэг, хөрөнгийн зардал хасагдсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 666,322.2 мянган төгрөгийн санхүүжилт, 241,227.8 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого, нийт 907,550 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлж, УБЕГ-ын орлого төвлөрүүлэх дансанд 225,392.8 мянган төгрөг, аймгийн төсвийн орлогын улсын тэмдэгтийн хураамжийн орлогоор 15,974.5 мянган төгрөгийг төвлөрүүлэн, урсгал үйл ажиллагаандаа 661,797.2 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 4,525.0 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 8,496,856.3 мянган төгрөг буюу 99,3 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд УБЕГ-аас Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн бэлтгэл ажилд 84,041.1 мянган төгрөгийн санхүүжилт хуваарилагдан ирүүлснийг, сонгуулийн арга хэмжээний зардалд 83,692.3 мянган төгрөгийн зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 348.8 мянган төгрөгийг Сангийн яамнаас татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

УБЕГ-аас Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын Койка төсөл буюу гадаадын хандив тусламжаар бэлтгэсэн 227,198.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй шилжүүлснийг болон 1,800.0 мянган төгрөгийн элэгдлээ нөхсөн зөөврийн компьютер ирснийг бүртгэж, 540.0 мянган төгрөгөөр дахин үнэлж үндсэн хөрөнгийн дансанд, 69,578.9 мянган төгрөгийн үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэж тайлагнасан.

УБЕГ-аас ирүүлсэн бараа материал дансанд бүртгэсэн цүнх, энгэрийн тэмдэг, маузны суурь гэх мэт бэлэг дурсгалын зүйлс 1,608.6 мянган төгрөгөөр, ариутгалын шүршигч машин 450.0 мянган төгрөгөөр, тасалгааны цэвэрлэгч хэрэгслийн багц 1,040.0 мянган төгрөгөөр, тасалгааны агаар ариутгагч 4,500.0 мянган төгрөгөөр, халуун хэмжигч 2,000.0 мянган төгрөгөөр, гар ариутгагч 7,280.0 мянган төгрөгөөр, нэг удаагийн бээлий 1,140.0 мянган төгрөгөөр, нэг удаагийн нүүрний хаалт 300.0 мянган төгрөгөөр, нэг удаагийн хамгаалах маск 27,000.0 мянган төгрөгөөр бэлтгэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3 болон 1.9 дахь заалттай нийцэхгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Бараа материалын дансны үлдэгдэл 69,343.4 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 23,730.9 мянган төгрөгөөр өссөн нь УБЕГ-аас нийлүүлсэн гар ариутгагч, нэг удаагийн хамгаалах маскийн үлдэгдэл нөлөөлж байна. Тухайлбал: Бусад хангамжийн материал дансны үлдэгдэл 25,657.7 мянган төгрөгийн 16,200.0 мянган төгрөг буюу 63,1 хувийг гар ариутгагч болон нэг удаагийн хамгаалах маск эзэлж байна. Бичиг хэрэг дансны үлдэгдэл 6,881.3 мянган төгрөг байгаагаас 2,800.5 мянган төгрөг буюу 40,7 хувийг Сонгуулийн зардлаас бэлтгэсэн принтерийн хор, цаасны үлдэгдэл эзэлж байна.

Аймгийн орон нутгийн төсвийн 2020 оны эх үүсвэрээр шийдвэрлэгдсэн 17,140.6 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 18,834.7 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг тайлант онд бүртгэж тайлагнасан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 2 мэдээллийг хугацаа хоцроосон төлөвтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж, бараа материалыг зөв ангилан бүртгэж тайлагнах гэсэн зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн № 600 тоот албан бичгээр ирүүлсэн боловч зөрчлийг таслан зогсоогүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилт, бараа материалын үлдэгдлийн зарцуулалтыг давтан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 39,763.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 31,224.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 183.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 5,106.8 мянган төгрөгийн албан шаардлага, 3,250.1 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Санхүү байдлын тайланд санхүүгийн программын алдаанаас шалтгаалан өмнөх үеийн үр дүн 17,899.2 мянган төгрөгийг зөрүүтэй татагдсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралт батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” -ын 8 дугаар заалтыг болон санхүүгийн тайлангийн “оршин байх”, “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Мөнгөн хөрөнгийн журналаас түүвэрлэн шалгахад Нэмэлт санхүүжилтийн 12,314.8 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг тооцооны дансаар бүртгэлгүй зардлын дансанд бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” 4.5, 4.21 дэх заалттай санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аж ахуйн материал дансанд 1,010.0 мянган төгрөгийн үнэтэй 10 ш ширээний бүтээлгийг орлогоор бүртгээд зарлагдсан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтыг болон санхүүгийн тайлангийн “оршин байх”, “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Эхний 6 сарын байдлаар шатахуун зарцуулалтыг шалгахад тус байгууллагын Xtral маркийн 06-25 ТӨВ дугаартай авто машинд 2021 оны 01 дүгээр сараас 5 дугаар сарын 12-ны өдөр хүртэл хугацаанд 100 км-т 15 л-ээр шатахууныг бодож байсныг 5 дугаар сарын 13-аас 6 дугаар сарын 11-ны хооронд 18 л -ээр бодож олгосноор 183,022 төгрөгийн шатахууныг зөрүүтэй олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг болон санхүүгийн тайлангийн “үнэлгээ”, “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.6-д “эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан” бол төлбөрийн акт тогтоох гэсний дагуу шийдвэрлэв.

4.3 Албан шаардлага

Үндсэн хөрөнгийн тоног төхөөрөмж дансанд бүртгэх 2 нэр төрлийн 1,490.0 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралт батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” 4.46 дахь заалтыг болон санхүүгийн тайлангийн “оршин байх”, “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1-д “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

Түүвэрт сонгогдсон бараа материалын үлдэгдлийг тулган шалгахад Тооллогын комисс нь 3,255.9 мянган төгрөгийн Сонгуулийн зардлаас бэлтгэсэн принтерийн хор, цаас, хуулийн этгээдийн уяатай хавтсыг болон 360.9 мянган төгрөгийн нэг удаагийн хамгаалах маск зэргийг НХМаягт БМ-8 маягтаар тоолж бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай

хуулийн 12 дугаар зүйл, 20.2.6 дахь заалт, ТБОНӨТХ-ийн 72 дугаар зүйлийн 72.4-ийн 1/эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах, 4/ комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх; гэсэн заалтыг болон санхүүгийн тайлангийн “оршин байх”, “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.2-д “хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг и-баримттай тулгалт хийхэд 3,250.1 мянган төгрөгийн гүйлгээний и-баримт зөрүүтэй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын НХМаягт 5 “Төлбөрийн баримт нь ... Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд ...” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан анхан шатны бүртгэлийн маягтыг зааврын дагуу бүрэн хөтөлж, хэвших ба худалдан авалт хийх бүрд и-баримтыг бүрдүүлж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Улсын бүртгэлийн хэлтэс	7	39,763.9	3	31,224.0	1	183.0	2	5,106.8	1	3,250.1